

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 84.4 хувийн гүйцэтгэлтэй байгаад сумдын төвлөрүүлэн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүд нөлөөлж байна.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2021 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2022/01/НА/СТА-ТЕЗ

Чойбалсан хот 2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn
Аудитор Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4207, Цахим хаяг: Ouyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Дүрслэлийн товъёог	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4

БҮЛЭГ 1. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч зарим нэр төрлийн татварын орлого тасарсан байна	5
1.1. Татварын орлогын талаар	7
1.2. Татварын бус орлогын талаар	8

БҮЛЭГ 2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ.

2.1. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас илүү төлөвлөж, зарцуулсан байна.	8
2.2. Төсөвт тодотгол хийхдээ төсвийн тухай хуульд заасан зарчмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	10
2.3. Төсвийн зарлага 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна.....	11

БҮЛЭГ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1.ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн дансны нийт зардал 7,559.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	14
3.2. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зарцуулалтын гүйцэтгэл	14

БҮЛЭГ 4. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИН.

4.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 84.4 хувийн гүйцэтгэлтэй байгаад сумдын төвлөрүүлэн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүд нөлөөлж байна.	16
4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 85 хувьтай байна.....	17

БҮЛЭГ 5: ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

БҮЛЭГ 5: ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН	18
ДҮГНЭЛТ:	19
Холбогдох байгууллагын санал:	19
ҮАГ-т хүргүүлсэн санал:	20
ЗӨВЛӨМЖ:	20
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДОА	Дорнод аймаг
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг Даргын тамгын газар
НА	Нотлох аудит
МУ	Монгол Улс
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хууль
НА	Нотлох аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СХС	Сум хөгжүүлэх сан
СС	Сангийн сайд
СЯ	Сангийн яам
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШТА	Шууд тайлагнах аудит

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Сангийн яамны хянасан дүнг орлогын төсвийн төсөлтэй харьцуулбал.	5
Дүрслэл 2	2018-2020 оны орлогын гүйцэтгэлтэй 2021 оны төлөвлөгөөг харьцуулан харуулбал.	6
Дүрслэл 3	Орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулалт.	6
Хүснэгт 1	Аймгийн 2021 оны төсвийн төслийг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт.	8 - 9
Хүснэгт 2	Аймгийн зардлын төлөвлөлтийг 2019-2020 оны гүйцэтгэлтэй харьцуулбал.	10
Хүснэгт 3	2021 оны зардлын төлөвлөлт гүйцэтгэлийн харьцуулалт.	12
Дүрслэл 4	Төсвийн гүйцэтгэлд эзлэх хувийг аймаг, сумаар харуулбал	13
Дүрслэл 5	Сумдын төсвийн гүйцэтгэлд эзлэх хувийг сум тус бүрээр харуулбал.	13
Дүрслэл 6	Төсөл, арга хэмжээний гүйцэтгээчийг сонгон шалгаруулсан байдлыг графикаар харуулбал.	13
Хүснэгт 4	Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт.	16

	<p>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ</p>
<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дорнод аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Орон нутгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 2021 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, • 2021 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл, • ТЕЗ-ийн хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшин, • Төрийн аудитын байгууллагаас 2021 оны төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлтийг хэрэгжилт.
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу орон нутгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай ирүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, • Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; • Нэмэлт төсвийн гүйцэтгэл, • Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн,
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>АДБОУС-100, АДБОУС-200, АДБОУС-2000, АДБОУС-4000.16-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS 6817-4:2020 "Төрийн аудит, Санхүүгийн аудитын тулгуур зарчим", АДБОУС-1000-1810 "Санхүүгийн аудитын удирдамж", арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/111 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж"-ийг баримтлан гүйцэтгэсэн бөгөөд аймгийн ерөнхий нягтлан бодогч, төсвийн ахлах мэргэжилтэнтэй ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Б.Оюунхэрлэн нар хийж гүйцэтгэлээ.</p> <p>Аудитын талбарын ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, тайланг ЯАГ-ын 2 дугаар газар болон аймгийн ИТХ, ТЕЗ-д 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүллээ.</p>

БҮЛЭГ 1. ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч зарим нэр төрлийн татварын орлого тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Төсвийн тухай хуулийн 4.1.8-д зааснаар жилийн төсвийн хязгаар нь орлогын доод, зарлагын дээд хэмжээ бөгөөд Сангийн яам 2021 оны нийт орлогыг 22.6 тэрбум төгрөгөөр хянасныг 22.9 тэрбум болгон 0.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж аймгийн ИТХ-ын 2020 оны 5 дугаар тогтоолоор батлуулсан байна.

Сангийн яамны хянасан дүнгээс нэмж баталсан орлогыг нэр төрлөөр нь дараах дүрслэлээр харуулбал байна.

Дүрслэл 1. Сангийн яамны хянасан дүнг орлогын төсвийн төсөлтэй харьцуулбал: /сая.төг/



Эх сурвалж: Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөл.

Дээрх дүрслэлээс малын тоо, толгойд ногдуулах орлогыг шинээр нэмж, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, татварын бус орлогуудыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан үндэслэлтэй нэмж баталсан боловч газрын дуудлага худалдааны орлогыг тооцоо, судалгаагүй, Газрын төлбөрийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу газрын төлбөр ногдуулах итгэлцүүрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шинэчлэн тогтоохоос өмнө нэмэгдүүлсэн байна.

Аймгийн 2021 оны төсөвт аймгийн ИТХ-ын 2021 оны 6/03 дугаар, 2021 оны 7/09 дүгээр тогтоолоор орлогын талаар доорх өөрчлөлтийг хийсэн байна. Үүнд:

- **Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 13-ны 6/03 дугаар тогтоолоор татварын орлогыг 1,240.3 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 115.8 сая төгрөгөөр бууруулан төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүнд ХХОАТ-ын буцаан олголтыг 365.0 сая төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлогыг 1,208.4 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 79.0 сая төгрөгөөр бууруулж, цалин хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлого, авто тээврийн хэрэгслийн албан татварыг 70.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.**

- **Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04-ний 7/09 дүгээр тогтоолоор татварын орлогыг 21,199.1 сая төгрөгөөр буюу Сангийн яамны хянасан дүнгээс 162.9 сая төгрөгөөр бууруулж, татварын бус орлогыг 1,775.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна. Энэ нь татварын болон татварын бус орлого нь нийлбэр дүнгээрээ Сангийн яамны хянасан хязгаарт багтсан ч газрын төлбөрийн орлогыг 583.2 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийг 225.6 сая төгрөгөөр хасаж төлөвлөсөн нь нөлөөлсөн байна.**

Аймгийн 2021 оны төсвийн нийт орлогыг 24,218.1 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2018-2020 оны гүйцэтгэлүүдээс 124.5-3,294.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дүрслэл 2. 2018-2020 оны орлогын гүйцэтгэлтэй 2021 оны төлөвлөгөөг харьцуулан харуулбал: /сая.төг/



Эх сурвалж: Дорнод аймгийн 2021 оны нэгтгэсэн тайлан.

Аймгийн 2021 оны төсвийн нийт орлого 27,710.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөгөөнөөс 14.4 хувь буюу 3,492.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Дүрслэл 3: Орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалт. /сая.төг/



Эх сурвалж: Дорнод аймгийн 2021 оны нэгтгэсэн тайлан.

Орлогын нийт төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна.

1.1.Татварын орлогын талаар:

- **Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татварыг** өмнөх оны гүйцэтгэлээс 938.9 сая төгрөг буюу 8.3 хувиар нэмж төсөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 14,601.0 сая төгрөг буюу төлөвлөснөөс 19.3 хувиар өссөн нь ковид цар тахалтай холбоотойгоор эрүүл мэндийн салбарт ажиллагсдын цалин хөлс, урамшууллыг нэмж олгосонтой холбоотой ХХОАТ-ын орлого нэмэгдсэн байна.
- **Үйл ажиллагааны орлогыг** өмнөх оны гүйцэтгэлээс 467.6 сая төгрөгөөр нэмж төсөвлөсөн байна. Гүйцэтгэл нь 812.5 сая төгрөг буюу төлөвлөснөөс 14.6 хувиар давж биелсэн нь патент болон худалдаа эрхлэгчтэй холбоотой татварыг төвлөрүүлж байсан бол татварын шинэчлэлтээр иргэдтэй холбоотой бүх татварыг энэ орлогын дансанд төвлөрүүлсэн нь нөлөөлсөн байна.
- **Хөрөнгийн орлогын татварыг** урьдчилан төлөвлөх боломжгүй тул өмнөх оны гүйцэтгэлийн түвшинг үндэслэн төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 208.0 сая төгрөгөөр буюу 19.2 хувиар давж биелсэн нь тайлант онд татварын баазаа бүрэн ашигласан, иргэдийн хадгаламж өссөнтэй холбоотой байна.
- **Шууд бус татварын орлогыг** өмнөх оны гүйцэтгэлээс 843.2 сая төгрөгөөр буюу 67.5 хувиар бууруулан төлөвлөсөн байна. Төлөвлөсөн хэмжээнээс 213.9 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Сангийн яам татварын хуулийн өөрчлөлттэй холбоотой төсвийн орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт хийгээгүй хянаж ирүүлсэн байна.
- **Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг** өмнөх оны гүйцэтгэлээс 177.5 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн нь гүйцэтгэлээр 801.9 сая төгрөг буюу төлөвлөснөөс 11.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Энэ нь орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөсөн байна.
- **Галт зэвсгийн албан татварын орлого** нь 2.7 сая төгрөг буюу 7.1 хувиар тасарсан байна. Энэ төрлийн орлогын гүйцэтгэл сүүлийн 3 жилийн байдлаар байнга тасарч байгаа нь Татварын хэлтэс дэх татвар ногдуулсан галт зэвсгийн тоо нь Цагдаагийн газарт бүртгэлтэй галт зэвсгийн тооноос зөрүүтэй байгаагаас шалтгаалсан байна. Үүнд Цагдаагийн газарт устгуулахаар өгсөн галт зэвсгийг тодорхой хугацаанд устгадаггүй хүлээгдэж байдаг нь нөлөөлсөн байна.
- **Авто тээврийн хэрэгслийн албан татварыг** өмнөх оны гүйцэтгэлээс 42.7 сая төгрөг буюу 10.6 хувиар бууруулж төсөвлөсөн байна. Гүйцэтгэл нь 435.6 сая төгрөг буюу төлөвлөгөөнөөс 8.9 хувиар давж биелсэн нь тайлант онд авто тээвэр эзэмшигч иргэдийн E-barimt -д тээврийн хэрэгслийн өмнөх оны мэдээллийг оруулж татварт хамруулах ажлыг зохион байгуулсан, мөн АТҮТ-ийн Дорнод салбартай хамтран авто тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулах тохиолдолд татварын албаны тодорхойлолтыг үндэслэн хасах арга хэмжээ зохион байгуулсан нь нөлөөлсөн байна.
- **Малын тоо толгойд ногдуулах албан татварыг** тайлант онд Сангийн яамнаас хянагдаж ирээгүй ч 396.1 сая төгрөгийн татвар төлөвлөж, гүйцэтгэлээр 702.4 сая төгрөг буюу 77.3 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Аймгийн хэмжээнд Хэрлэн сум нь **улсын тэмдэгтийн хураамжийг** орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 23.4.9 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд Төрийн аудитын байгууллагаас 2020 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитуудаар уг асуудлын талаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байгаа тул УАГ-т уламжилж МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дахин тусгуулах саналтай байна. Хэрлэн сум нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгохтой холбоотой улсын тэмдэгтийн хураамжаас 2021 онд 474.5 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, 419.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- **Газрын төлбөрийг** 854.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 212.6 сая төгрөг буюу 33.1 хувиар өссөн байна. Гүйцэтгэлээр 14.8 сая төгрөг буюу 1.8 хувиар тасарсан нь цар тахалтай холбоотой уул уурхайн ашиглалт, олборлолт эрхэлдэг

зарим компани болон үр тарианы компаниуд бүрэн ажиллаагүйгээс татварын орлогыг дутуу төлсөнтэй холбоотой байна.

- **Ус рашааны нөөц ашигласны төлбөрийг** 3,890.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 247.6 сая төгрөг буюу 6.0 хувиар буурсан байна. Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын 3,500.0 сая төгрөгийг газрын тосны 19, 21-р талбайд үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин тамсаг” ХХК, 390.0 сая төгрөгийг бусад аж ахуйн нэгж байгууллагаас төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 3,561.9 сая төгрөг буюу 328.1 сая төгрөгөөр тасарсан нь 2021 онд “Петрочайна Дачин тамсаг” ХХК бүрэн хэмжээгээр ажиллаагүй, усны төлбөрийг тоолуурын заалтаар авдаг нь нөлөөлсөн байна.
- **Ан амьтны нөөц ашигласны төлбөр** нь жил бүхэн төлөвлөх боломжгүй орлого бөгөөд тайлант онд шонхор шувууны зөвшөөрөл, загас агнуураас 37.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

1.2. Татварын бус орлогын талаар:

Татварын бус орлого нь 4 нэр төрлийн орлогоос нийт 3,974.4 сая төгрөг буюу 31.6 хувиар давж биелсэн байна.

- **Бусад татвар буюу нэр заагдаагүй татварын орлого** нь урьдчилан тооцох боломжгүй орлого тул өмнөх оны гүйцэтгэлийн түвшинд буюу 2,000.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 166.4 сая төгрөг буюу 8.3 хувиар давж биелсэн байна.
- **Торгуулийн орлого** нь тодорхойлох боломжгүй орлого тул өмнөх оны гүйцэтгэлийн түвшинг үндэслэн 843.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 521.8 сая төгрөг буюу 61.8 хувиар давж биелсэн байна.
- **Хөрөнгийн орлогыг** 119.7 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 269.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Энэ нь Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийг худалдан борлуулж олсон орлогоос бүрдэж байна.
- **Төсөвт байгууллагын өөрийн орлогыг** өмнөх оны гүйцэтгэлийн түвшинд буюу 55.9 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2.8 сая төгрөгөөр тасарсан байна.

БҮЛЭГ 2. ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамны хянасан зардлын хязгаараас илүү төлөвлөсөн байна.

Аймгийн 2021 оны төсвийн төслийн суурь зарлагыг Сангийн яамнаас баталсан дээд хязгаараас 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 19.3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Аймгийн 2021 оны төсвийн төслийг Сангийн яамны баталсан суурь хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Аймгийн 2021 оны төсвийн төслийг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт /сая.төг/

№	Үзүүлэлт	СЯ хянасан дүн /анх/	2021 оны төсөв	Зөрүү	Өөрчлөлтийн хувь
1	Аймгийн ИТХ	196.0	268.7	72.7	15.73
2	Аймгийн ЗДТГ	1,653.8	1,867.1	213.3	12.94
3	Сумдын ИТХ	865.6	992.8	127.2	14.69
4	Сумдын ЗДТГ	5,526.1	6,289.2	763.1	13.81
5	Орон нутгийн өмч	164.5	203.8	39.3	23.94

6	Санхүү хяналт аудит	146.8	220.2	73.4	49.99
7	сум дундын ойн анги	62.0	79.6	17.6	28.40
8	Ахмадын хороо	25.5	25.5	-	-
9	Ахмадын чөлөөт цагийн төв	42.1	42.1	-	-
10	Хот тохижуулахын зардал	743.2	1,270.9	527.7	71.00
11	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ	1,035.5	1,035.5	-	-
12	БОАЖГ	466.2	444.8	(21.4)	(4.57)
13	Хотын нийтийн тээвэр	66.0	165.0	99.0	150.00
14	Мал эмнэлгийн үйлчилгээ	345.8	345.8	-	-
15	Халамжийн сан	182.6	182.6	-	-
16	Автозамын сан	333.0	333.0	-	-
17	Ус хангамжийн татаас	64.0	64.0	-	-
18	Агаарын бохирдол	10.0	10.0	-	-
19	ЕБС, СӨБ-ийн тогтмол зардал	2,228.8	2,228.8	-	-
20	Соёл спортын ТШЗ-ийн тогтмол зардал	1,133.0	1,242.5	109.5	9.67
21	Музей	404.8	426.8	22.0	5.45
22	Хөгжимт драмын театр	1,104.5	1,104.5	-	-
23	Номын сан	253.0	253.0	-	-
24	Хүүхэд хамгааллын ТШЗ-ийн тогтмол зардал	14.6	14.6	-	-
25	Сумдын эрүүл мэндийн төв	246.3	246.3	-	-
26	Газрын харилцаа барилга хог байгуулалтын газрын тогтмол зардал	23.8	23.8	-	-
	Нийт дүн	17,337.2	19,381.2	2,044.0	11.51

Эх сурвалж: Дорнод аймгийн 2021 оны төсвийн төсөл.

Сангийн яамны хянасан зардлын хязгаараас хэтрүүлэн зардлыг төлөвлөхөд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

1. Сангийн яам нь ТЕЗ-ийн төсвийн төсөлд өгсөн санал, орон тоог бодит нөхцөл байдалтай уялдуулан тооцохгүй Засгийн газрын тогтоолд заасан орон тоогоор баталж, нийтлэг үйлчилгээний албан хаагчдыг оруулан тооцоогүйгээс.
2. Санхүүгийн хяналт, аудитын алба 5, Орон нутгийн өмчийн газар 3, аймгийн ИТХ 5, Хэрлэн сумын ИТХ 4, сумдын ЗДТГ 14 орон тоогоор сангийн яамны хязгаараа хэтрүүлэн төлөвлөсөн.
3. Аймгийн ИТХ-д суудалтай намуудад олгосон дэмжлэг. Төрийн аудитын байгууллагаас 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын дагуу аймгийн ИТХ-ын 2021 оны 6/04 дугаар тогтоолоор дээрх зөрчлийг зогсоосон.
4. Шинээр орон нутгийн өмчит Байгаль хамгаалалтын захиргаа, Жижиг дунд үйлдвэрлэлийн төвийг байгуулсан.
5. Сангийн яамны хянасан дүнд тусгагдаагүй аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг нэмж тусгасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зардлыг тайлант онд 84.7 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 2.Аймгийн зардлын төлөвлөлтийг 2019-2020 оны гүйцэтгэлтэй харьцуулбал. /сая.төг/

Зардлын ангилал	2020 он			2021 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Урсгал зардал	61,767.69	57,676.06	93.4	65,770.8	62,153.7	94.5
хөрөнгийн зардал	14,935.53	13,628.87	91.3	17,370.4	13,760.5	79.2
Эргэж төлөгдөх зээл	1,382.82	561.78	40.6	1,524.5	961.0	63.0
Нийт дүн	78,086.04	71,866.70	92.0	84,665.70	76,875.20	90.8

Эх сурвалж: Дорнод аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Хүснэгтээс харахад 2021 оны зардлыг төлөвлөхдөө өмнөх оны зардлын гүйцэтгэлээс урсгал зардлыг 14.0 хувь, хөрөнгийн зардал 27.4 хувь, эргэн төлөгдөх зээлийг 171.3 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

Ковид-19 цар тахал 2020 онд дэгдсэнтэй холбоотойгоор жижиг бизнес эрхлэгчдийн СХС-гаас авсан зээлийн эргэн төлөлт 35.7 хувь буюу 561.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 2021 онд эргэн төлөлтийг 1.5 тэрбум төгрөг байхаар 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2.2. Төсөвт тодотгол хийхдээ төсвийн тухай хуульд заасан зарчмыг баримталж ажиллаагүй байна.

Аймгийн 2021 оны төсөвт аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 4 дүгээр, 2021 оны 5/02 дугаар тогтоолоор 2 удаа өөрчлөлт, 2021 оны 6/03 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна. Үүнд:

- **Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зардлыг 80.0 сая төгрөгөөр бууруулан, 2020 оноос шилжиж ирсэн байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх 80.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих 82.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн, 1 төсөл, арга хэмжээг 82.0 сая төгрөгөөр бууруулан өөрчлөлт хийсэн байна.**
- **Аймгийн ИТХ-ын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 5/02 дугаар тогтоолоор Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зардлыг 500.0 сая төгрөгөөр урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр, орон нутгийн хөрөнгө оруулалтын 5 арга хэмжээг 324.5 сая төгрөгөөр шинээр нэмсэн, 144.0 сая төгрөгийн 3 арга хэмжээг хасаж, 5 арга хэмжээг 180.5 сая төгрөгөөр бууруулан, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих 145.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг шинээр, 15.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг нэмэгдүүлэн, 100.0 сая төгрөгийн 2 ажлыг хасан, 60.0 сая төгрөгийн 4 ажлыг бууруулан өөрчлөлт хийсэн байна.**
- **Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 6/03 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын 106.0 сая төгрөгийн 8 арга хэмжээг шинээр нэмэн, 4 арга хэмжээг 140.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 73.0 сая төгрөгийн 4 арга хэмжээг хасаж, 4 арга хэмжээг 50.0 сая төгрөгөөр бууруулан, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих 3.8 сая төгрөгөөр 1 арга хэмжээг бууруулан, 373.0 сая төгрөгийн 10 арга хэмжээг шинээр нэмэгдүүлэн, 120.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг хассан байна. Мөн байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх 40.0 сая төгрөгийн 2 арга хэмжээг хасаж, 17.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг нэмж, 7.0 сая төгрөгийн 3 арга хэмжээг бууруулан тодотгол хийсэн байна.**

Аймгийн 2021 оны төсөвт оруулсан өөрчлөлтийг ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалттай тулган үзэхэд:

1. Аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 82.0 сая төгрөгийн 3 ажлыг нэмсэн нь 2020 оноос шилжин ирсэн ажлыг орхигдуулснаас, 80.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг шинээр нэмж төлөвлөсөн.
2. Коронавирус /Ковид-19/ идэвхжилт нэмэгдэн төсөв хүрэлцэхгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор урьд оны үлдэгдлээс Засаг даргын нөөц хөрөнгийг 500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхийн зэрэгцээ Орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих 469.5 сая төгрөгийн 10 арга хэмжээг шинээр нэмж, 15.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг нэмэгдүүлэн, 240.5 сая төгрөгийн 9 арга хэмжээг бууруулан, 244.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хасаж төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар хуулийн 6.2.6.а-д “**тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх**” гэсэн төсвийн зарчимтай нийцэхгүй байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн дагуу аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 6/03 дугаар тогтоолоор Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон 309.0 сая төгрөг, аймгийн ерөнхий харилцах дансны урьд оны үлдэгдлээс 915.1 сая төгрөг, ОНХС-гийн урьд оны үлдэгдлээс 205.9 сая төгрөгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлж, Орон нутгийн төсвийн орлогыг 1,099.4 сая төгрөгөөр бууруулан, Орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих 496.0 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээг шинээр нэмж, 140.0 сая төгрөгийн 4 арга хэмжээг нэмэгдүүлэн, 60.8 сая төгрөгийн 8 арга хэмжээг бууруулан, 233.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг хасаж төлөвлөсөн байна.

ТЕЗ нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1а/5843 дугаар албан тоотыг үндэслэн А/630 дугаар тушаалаар 1 удаа төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн тодотголоор 477.0 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ хасагдсан нь дараах нөхцөл байдлаас шалтгаалсан байна. Үүнд:

- Тендер шалгаруулалтыг зарласан боловч оролцогч ирээгүй,
- Эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тусгай зориулалтын машины үнэ нэмэгдсэн,
- Цар тахалтай холбоотойгоор баяр наадмын үйл ажиллагаа, уулзалт, сургалтад төлөвлөсөн арга хэмжээ хийгдээгүй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь ТЕЗ-ийн боловсруулан өргөн барьсан төсвийг батлахдаа зураг төсөв хийгдсэн эсэх, тооцоо бодитой үнэн зөв эсэх, тухайн төслийн санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээтэй эсэх, бараа материалын үнийн өсөлтийг тооцон үзэлгүйгээр баталж байна.

2.3. Төсвийн зарлага 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 84,665.7 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс жилийн эцсийн байдлаар 90.8 хувь буюу 76,875.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 3. 2021 оны зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн харьцуулалт.

/сая.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	2021 он		Хувь
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,665.7	76,875.2	90.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,770.8	62,153.7	94.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,370.4	13,760.5	79.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГ ДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,524.5	961.0	63.0

Эх сурвалж: Дорнод аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Төсвийн зарлагыг 9.2 хувиар хэмнэсэн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна.

Үүнд:

- Урсгал зардлыг дутуу зарцуулсан нь тайлант онд цар тахлын нөлөөгөөр тэтгэвэрт гарсан ажилтны оронд нөхөн томилгоо хийгдээгүй, Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн илүү цагийн цалин хөлс, үдийн цай хоолны зардал, төрийн байгууллагуудын дотоод томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардлуудын гүйлгээг Сангийн яамнаас хязгаарласан.
- Хөрөнгийн зардал гүйцэтгэл дутуу гүйцэтгэлтэй байгаа нь тэвчиж болох зардлыг Сангийн яамнаас хязгаарласан.
- Эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 63.0 хувиар буурсан нь тайлант онд СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэр төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй учир зээл олголтыг олгоогүй.

Цар тахлын нөлөөллөөс Сангийн яам төсөвт хязгаарлалт хийснээс шалтгаалан төсөвт хэмнэлт гарсан боловч Төрийн аудитын байгууллагаас 2021 оны төсвийн төсөлд өгсөн тэвчиж болох үр ашгийг сайжруулах санал дүгнэлтэд тусгагдсан, шинээр төсөвт нэмж тусгасан доорх 337.5 сая төгрөгийн 8 арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

Төрийн аудитын байгууллагаас аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгсөн тэвчиж болох зардалд дурдагдсан:


1. Аймгийн ОНХС-гийн “Жишиг гудамж төсөл эхлүүлэх /Хэрлэн сум/” 99.4 сая,
2. Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, тохижилт /Хэрлэн сум/ 133.8 сая,
3. Ахмад настны байрны их засвар /Дашбалбар сум/ 27.8 сая,
4. Партизан Содномдаржаагийн хөшөөний засвар, тохижуулалт 20.0 сая,
5. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Чойбалсангийн хөшөөг сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэх /Аймгийн музей/ 11.5 сая,

Аймгийн ИТХ-ын 2021 оны төсөвт өөрчлөлт оруулсан 5/02 дугаар тогтоолоор шинээр нэмж тусгасан:

6. Чойбалсан сумын наадмын талбайн тохижилт 25.0 сая,
7. Чойбалсан суманд ахмад дайчдын дурсгалын хөшөө 10.0 сая,
8. Манлайбаатарын онголсон газарт хөшөө барих 10.0 сая,

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцэхгүй байна.

Дүрслэл 4: Төсвийн гүйцэтгэлд эзлэх хувийг аймаг, сумаар харуулбал. /сая төг/




Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нийт зардлын гүйцэтгэлийн 25 хувь буюу 19.454.1 сая төгрөгийг аймаг, 75.0 хувь буюу 57.421.1 сая төгрөгийн сумд эзлэж байна.

Эх сурвалж: Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл.

Сумдын нийт зарлага 62.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс жилийн эцсийн байдлаар 92.0 хувь буюу 57.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Дүрслэл 5: Сумдын төсвийн гүйцэтгэлд эзлэх хувийг сум тус бүрээр харуулбал.




Эх сурвалж: Аймгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл.

Аймгийн Орон нутгийн өмчийн алба нь нийт 13,215.6 сая төгрөгийн 129 төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнд:

- ✓ Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1,439.2 сая төгрөгийн 23 арга хэмжээ,
- ✓ Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 256.9 сая төгрөгийн 5 арга хэмжээ,
- ✓ Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 8,613.1 сая төгрөгийн 73 арга хэмжээ,
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх 614.1 сая төгрөгийн 16 арга хэмжээ,
- ✓ "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл"-ийн санхүүжилтээр 1,410.0 сая төгрөгийн 8 арга хэмжээ,
- ✓ Бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн 882.3 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ

Дүрслэл 6: Төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан байдлыг графикаар харуулбал.



Эх сурвалж: ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

БҮЛЭГ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ.

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансны нийт зардал 7,559.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 1,258.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 5,720.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 423.9 сая төгрөг, хандив, тусламжаас 167.8 сая төгрөг, нийт 7,570.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 1,052.2 сая, байр ашиглах зардалд 22.6 сая, хангамж, бараа материалын зардалд 228.7 сая, нормативт зардалд 1,277.5 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 501.0 сая, дотоод албан томилот 19.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 429.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2,237.6 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 508.5 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 559.5 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 618.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 45.0 сая төгрөгийг тус тус зарцуулан, 60.2 сая төгрөгийг төвлөрүүлэн, 11.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.2. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зарцуулалтын гүйцэтгэл.

Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл

бүрдүүлэхтэй холбоотой зардалд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1,162.1 сая төгрөгийг төлөвлөн 1,101.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн онцгой комисст 2021 онд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан 16 аж ахуй нэгж, 6 иргэнээс 112.9 сая төгрөгийн мөнгөн, 22 аж ахуй нэгж, 2 иргэнээс 111.4 мянган төгрөгийн мөнгөн бус, нийт 224.3 сая төгрөгийн хандив тусламжийн орлогыг бүрдүүлэн 202.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын 100070031402 тоот харилцах дансанд 2021 оны жилийн эцсийн байдлаар 6.1 сая төгрөг, 15.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

БҮЛЭГ 4. ТЕЗ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОТ ТҮВШИН

4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 84.4 хувийн гүйцэтгэлтэй байгаад сумдын төвлөрүүлэн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнүүд нөлөөлж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт хамрагдах 24 төсөл арга хэмжээ батлагдсанаас орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны 1 хөтөлбөрт хамаарах 3 арга хэмжээ, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт хамаарах орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх 14, улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх 7 арга хэмжээ байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах бусад хөтөлбөр, арга хэмжээнүүдээс 2,786.9 сая төгрөгийн доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт

Багш нарын сургалт, дадлагын төв байгуулах – 55.0 сая төгрөг
Ардын хувьсгалын 100 жил, Аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн баяр наадмын үйл ажиллагааны зардал-40 сая төгрөг
Цэнгэлдэх хүрээлэнгийн засвар тохижилтын зардал-65.0 сая төгрөг
Соёлын төвийн дээврийн засвар /Хөлөнбуйр сум/ -15.0 сая төгрөг
Сурагчийн автобус /Хэрлэн, Баян-Уул сум/-110.0 сая төгрөг.

Сумдын орон нутгийн хөрөнгө оруулалт

Булган сумын хөрөнгө оруулалтын бус арга хэмжээний “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын дэмжлэг”- 3.5 сая төгрөг
Дашбалбар сумын 15.0 сая төгрөгийн "сумын төсвийн 1 км сайжруулсан замын ажил" 66.7 хувийн гүйцэтгэлтэй
Баяндун сумын Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 52.0 сая төгрөгийн 4 ажил хийхээр баталснаас 20.0 сая төгрөгийн 3 ажил нь огт хийгдээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө:

Аймгийн орон нутгийн хөгжлийн сан

Өмнөх оноос шилжиж ирсэн 120.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ нь огт хэрэгжээгүй. Мөн өмнөх оноос шилжиж ирсэн Сэргэлэн сумын Орон нутгийг судлах төвийн өргөтгөлийн ажил 65.0 сая төгрөгөөр батлагдаж 24.5 сая төгрөгийн ажил хийгдэж 62.3 хувийн гүйцэтгэлтэй байна.
Шинээр барилга, байгууламж, өмч бий болгох 1,026.3 сая төгрөгийн 18 ажил огт хийгдээгүй, 418.0 сая төгрөгийн төсөвтэй 4 ажил нь 35.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумдын орон нутгийн хөгжлийн сан

Баянтүмэн суманд "Сүлжээний антен", "Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн засвар", "Цэцэрлэгт хүрээлэн /морины/", "Худгийн цооног" гаргах нийт 85.0 сая төгрөгийн 4 арга хэмжээ огт хийгдээгүй байна.

Сэргэлэн сумын "Төвлөрсөн хогийн цэгүүдийг цэвэрлэх, радиусыг багасгах", "Булгийн эх хаших хамгаалах", "Гүн өрмийн худаг гаргах" нийт 84.0 сая төгрөгийн 3 арга хэмжээ огт хийгдээгүй байна

Хэрлэн сумын "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна авто зогсоол байгуулах /3 дугаар баг, 6 дугаар цэцэрлэг/" 16.1 сая төгрөгийн 1 ажил огт хийгдээгүй байна

Чойбалсан сумын "Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж", "Маршалын төрсөн газар угталтын талбайн тохижилт" нийт 55.0 сая төгрөгийн 2 арга хэмжээ огт хийгдээгүй байна

Цагаан-Овоо сумын "Нийтийн эзэмшлийн талбайн засвар арчилгаа" 13.2 сая төгрөгийн ажил 45.6 хувийн, "Шинэ усан сан төсөл" 60.0 сая төгрөгийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй, "Багийн Иргэдэд үйлчлэх төв шинээр барих", "Наадмын талбайн тохижилт", "зураг төсөө хийлгэх ажил", "Хоёрдогч түүхий эд авах цэг байгуулах, нийтийн эзэмшлийн хог хаягдал цэвэрлэх", "Гудамжны камержуулалт", "Хогны сав байршуулах", "Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /ковидоос урьдчилан сэргийлэх/" нийт 161.1 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ огт хийгдээгүй байна.

Булган сумын "Угаалгын ванн шинээр барих", "Наадмын талбайг тохижуулах засварлах", "Гал түймрээс сэргийлэх зурвас татах" нийт 11.9 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ огт хийгдээгүй байна.

Дашбалбар сумын "Буриадын өв соёлын музей барилга"-ын 1,008.7 сая төгрөгийн 1 ажил 59.5 хувийн гүйцэтгэлтэй, "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал, сургалт сурталчилгааны зардал"-ын 20.0 сая төгрөгийн 1 арга хэмжээ огт хийгдээгүй байна.

Баян-Уул сумын "Алслагдсан багуудын мэдээллийн төвийн тохижилт"-ын, "Хөдөөгийн багуудад бэлчээр усжуулах гүн өрмийн худаг гаргах", "Малын үүлдэр угсаа сайжруулах", "Мал угаааврын ванн худалдан авах", "Сумын газар нутгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил", "Газар нутгийн нэршил тодорхойлох ажил" нийт 126.7 сая төгрөгийн 6 арга хэмжээ огт хийгдээгүй байна.

Матад сумын "зураг төсвийн ажил"-ын 27.4 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн

Халхгол сумын "Шинэ сум, хуучин сум дунд холбосон засмал зам" болон "орон нутгийн өмчийн барилга байгууламжийн засварын ажлууд" нь 91.8 сая төгрөгийн ажил дутуу буюу 77.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөлөнбуйр сумын "Хоггүй Хөлөнбуйр төсөл", "Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ", "Гамшгаас хамгаалах" ажлууд нь 12.3 сая төгрөгийн ажил дутуу буюу 46 хувийн гүйцэтгэлтэй байна.

Баяндун сумын "Цэцэрлэгт хүрээлэн", "Угааврын ванн" барих 35.1 сая төгрөгийн 2 ажил огт хийгдээгүй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээ 92.1 хувь, сумдын төвлөрүүлэн захирагчдын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээ 76.7 хувь, аймгийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн хувьд 84.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний 15.6 хувь хэрэгжээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Энэ нь орлогын эх үүсвэр нь оны эцэст бүрдсэн, цаг үеийн нөхцөл байдлаас үүссэн хилийн хорио, материалын хомсдол, үнийн өсөлт зэргийг тооцоон төлөвлөөгүйгээс зарлагдсан хөтөлбөр арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр арга хэмжээнүүдэд орон нутгийн төсөвт байгууллагууд болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ахмад настны хөгжил хамгаалал, нийгмийн халамж, мал эмнэлгийн үйлчилгээ, хот тохижилт, авто замын сан, мал хамгаалах сан, орон нутгийн

төсвийн болон хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээтэй холбоотой үйл ажиллагаанууд байна. Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт “Төсвийн байгууллагын төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.” гэж заасны дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрт хамаарах орон нутгийн ТШЗ-ын байгууллагуудын ажлын биелэлтийг дүгнэн 80.1-94.7 хувьтай дүгнэсэн байна. Эдгээр төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар, хэрэгжүүлэх хөтөлбөр нь зорилтот үр дүндээ хүрээгүй ТШЗ байгаагүй тул дээрх үнэлгээ нь үндэслэлтэй байна.

ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба нь аймгийн ОНХС болон 14 сумын 2020 он, 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх хөрөнгө оруулалтын төлөвлөлт гүйцэтгэл, худалдан авах ажиллагаанд аудит хийсэн байна. Аудитаар нийт 4,361.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 51.8 сая төгрөгийн 16 төлбөрийн акт тогтоон, 1,783.1 сая төгрөгийн 31 албан шаардлага, 2,526.6 сая төгрөгийн зөрчилд 142 зөвлөмж өгч ажилласан байна.

4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 85 хувьтай байна.

Өмнөх оны аудитаар төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас 2,330.5 сая төгрөгийг хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан зөрчилд албан шаардлага, Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод хяналтыг үр дүнтэй, цаг хугацаанд зохион байгуулах зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 4

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	2,330.5	1	2,330.5	-	-	70
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100
Нийт	2	2,330.5	2	2,300.5	-	-	85

Эх сурвалж: Дорнод аймгийн ТЕЗ-ийн 2021.12.08-ны өдрийн 8/2378 тоот албан бичиг.

БҮЛЭГ 5. ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН.

Аймгийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн үр ашгийг сайжруулах 7,530.4 сая төгрөг, төсвийн орлогыг нэмэгдүүлэх 37.4 сая төгрөг, төсвийн зарлагыг бууруулах 2,658.2 сая төгрөгийн санал, дүгнэлтийг хүргүүлэн ажилласан. Үүнд:

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх- 37.4 сая төгрөг,
2. Төсвийн зарлагыг бууруулах- 2,658.2 сая төгрөгийн 77 төсөл, арга хэмжээ,
 - Төсвийн зарлагын төлөвлөлттэй - 19.9 сая төгрөг,*
 - Орон нутгийн хөрөнгө оруулалт - 389.0 сая төгрөг,*
 - Хөрөнгө оруулалтын бус - 560.4 сая төгрөг,*
 - Орон нутгийн хөгжлийн сан - 1,553.8 сая төгрөг,*
 - Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал - 135.1 сая төгрөг,*
3. Төсвийн үр ашгийг дээшлүүлэх - 7,530.4 сая төгрөгийн 54 төсөл, арга хэмжээ,
 - Төсвийн орлогын үр ашгийг нэмэгдүүлэх - 2,038.0 сая төгрөг*
 - Төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах - 1,996.9 сая төгрөг*
 - Орон нутгийн хөрөнгө оруулалт - 124.4 сая төгрөг*
 - Хөрөнгө оруулалтын бус - 312.5 сая төгрөг*
 - Орон нутгийн хөгжлийн сан - 2,653.4 сая төгрөг*
 - Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал - 390.1 сая төгрөг*
 - Автозамын сан - 50.0 сая төгрөг,*

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас өгсөн санал дүгнэлтийн дагуу төсвийн орлогыг 37.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, төсвийн зарлагыг 1,423.2 сая төгрөгөөр бууруулан, төсвийн үр ашгийг 2,197.2 сая төгрөгөөр сайжруулан төсвийн төсөлд тусгасан байна.

Аймгийн 2021 оны төсвийн төсөлд газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт зохион байгуулалтын 1,819.0 сая төгрөгийг тооцоо судалгаа нотлох баримтад үндэслээгүй тул орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжгүй байна гэж дүгнэн санал өгсөн боловч хүлээн авалгүй ИТХ-аар баталсан ч жилийн дундуур төвлөрүүлэх боломжгүй болж ИТХ-ын 8 дугаар сарын 13-ны өдрийн 6/03 дугаар тогтоолоор хасагдсан байна.

Төсвийн тодотголд Төрийн аудитын байгууллагаас санал, зөвлөмж өгөөгүй.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн ч зарим нэр төрлийн орлого тасарсан байна.
2. Аймгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан байна.
3. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтын дагуу тодотгол хийсэн байна.
4. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээ 92.1 хувийн гүйцэтгэлтэй байна.
5. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:

МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000 Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, Факс: 7058-4584

2022.05.02 № 1/974
танай -ны № -т

Санал хүргүүлэх тухай

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа.

Тайланд тусгагдсан зарим асуудлуудтай холбоотой дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1.Тайлангийн ерөнхий дүгнэлтэд хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг 84.4 хувьтай гэж дүгнэсэнд сумдын төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын болон хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр арга хэмжээний хэрэгжээгүй ажлыг хамруулан тооцсон байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан аймгийн Засаг даргад хамаарах хөтөлбөр арга хэмжээнд сумдын хөтөлбөр, арга хэмжээнүүд байхгүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17-д зааснаар сумдын Засаг дарга нь сумын төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд аймгийн төсвөөс сумдад олгох орлогын шилжүүлэг нь аймгийн төсөвт тусгагдан батлагдаж, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг сумын Засаг дарга бие даан төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг хариуцдаг.

2.Дүгнэлтэд тусгагдсан төсөвт тодотгол хийх нөхцөл бүрдээгүй байхад тодотгол хийсэн гэсэн асуудлын тухайд 2020 оны 12 сард хийсэн өөрчлөлт нь өмнөх онд он дамжин хэрэгжихээр батлагдсан арга хэмжээнүүдийг орхигдуулсан алдааг залруулж төсвийн нийт дүнд өөрчлөлт оруулалгүйгээр орон нутгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр арга хэмжээг тус тусын эх үүсвэр дотор нь нэмж хасах зохицуулалт байдлаар хийгдсэн.

Төсвийн жилийн дундуур 6 дугаар сард хийсэн өөрчлөлт нь мөн л орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний нийт дүнд өөрчлөлт оруулалгүйгээр тухайн эх үүсвэр дотор нь зохицуулалт хийсэн.Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.а-д заасан "тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх" гэсэн зарчимд нийцсэн болно. Урсгал зардлын тухайд Ковид-19 халдварт цар тахлын тархалт нэмэгдэн Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалт 90 орчим хувьд хүрч цаашид зарлага хэтэрч, төсөв хүрэлцэхгүй болох нөхцөл байдал үүссэн.

010522407

2

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-д заасны дагуу аймгийн Засаг дарга тухайн шатны төсвийн хөрөнгийн зардлыг хасаж урсгал зардалд шилжүүлэх зохицуулалтыг хийх эрхтэй ч төрийн худалдан авалтыг бууруулахгүй байх, төлөвлөгдсөн арга хэмжээг зогсоохгүй байх чиглэлийг баримтлан орон нутгийн төсвийн харилцах дансны үлдэгдлээс дутагдаж байгаа эх үүсвэрийг нөхсөн дүнгээр нийт төсвийн дүнг нэмэгдүүлэх саналыг аймгийн ирээдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлэн төсөвт өөрчлөлт хийсэн.

Харин 8 дугаар сард хийсэн өөрчлөлт нь улсын төсөвт хийгдсэн тодотголыг дагаж хийгдсэн болно.

Иймд дээрх тайлбаруудыг судлан үзэж аудитын тайланд холбогдох өөрчлөлтийг оруулж өгнө үү.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг аймгийн болон сумдын төвлөрүүлэн захирагчдын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг тус бүрээр гарган өөрчлөлтийг тайланд орууллаа.
2. Төсөвт тодотгол хийхдээ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.а-д **“тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх”** гэсэн зарчмыг баримтлаагүй гэж өөрчлөлт оруулав.

САНАЛ:**Үндэсний аудитын газарт:**

МУ-ын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дараах асуудлыг тусгуулах саналтай байна. Үүнд

1. Улсын төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийн орлогыг сумын төсвийн бүрэлдэхүүнд оруулан төлөвлөн зарцуулж байгааг Төсвийн тухай хуулийн 23.4.9 дэх заалттай нийцүүлэх талаар Сангийн яаманд уламжлах.
2. Төсвийн хязгаарыг хянахдаа сумдын нөөц хөрөнгө болон төсөвт байгууллагуудын орон тоог бодитой тооцох талаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлэх.
3. Төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөж, зарцуулсан зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар Төрийн аудитын байгууллагын бодлого, чилэлд тусгах.
4. Төрийн аудитын байгууллагаас аймгийн ИТХ болон тэргүүлэгчид, төсвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хэлэлцэн, батлах үед зөвлөх эрхтэй оролцох эрх зүйн орчныг сэргээх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөрд

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь ТЕЗ-ийн боловсруулан өргөн барьсан төсвийг батлахдаа зураг төсөв хийгдсэн эсэх, тооцоо бодитой үнэн зөв эсэх, тухайн төслийн санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээтэй эсэх, бараа материалын үнийн өсөлт, тооцоо судалгааг үндэслэн батлах.
2. Төсвийн тухай хуульд заасан үндэслэл, шаардлагад нийцүүлэн төсөвт тодотгол хийж байх.

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд

1. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасны дагуу батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хүрэх үр дүнг ханган ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 10

Чойбалсан хот

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын аудитын хоёрдугаар газарт болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга М.Энхтөр, Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Нармандах-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

